



МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.06.20, ПҮРЭВ ~ №117 (1169)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~


ҮНЭ: 1000Т

<b>Нутгийн өөрөө удирдах ёсны үндсэн нэгж нь сум, дүүрэг байна</b> Намуудыг тунгалаг байлгаг гэвэл төрөөс дэмжих хэрэгтэй. <b>&gt;2</b>	<b>Тансаг зах зээлийг тэргүүлэгчийн хөрөнгө \$100 тэрбумыг давлаа</b> Түүний нийт хөрөнгө энэ жил бараг 32 тэрбум ам.доллараар өсөв. <b>&gt;9</b>	<b>Төвбанк бодлогын хүүг хэвээр үлдээв</b> Эрсдэлээс сэргийлэн, санхүүгийн нөөцөө нэмэгдүүлэх шаардлагатай. <b>&gt;11</b>	<b>FULL ENGLISH PAGE INSIDE</b> <b>&gt;7</b>
--	--	--	---

## ОНЦЛОХ

**УЛС ТӨР**  
**УИХ-ын даргын захирамжаар** гишүүд тойрогтоо ажиллан, ҮХ-д санал авч байна.  
**Засгийн газар төр хувийн** хэвшлийн хүрээнд байгуулсан концессын 11 гэрээг цуцаллаа.  
**Гэр бүлийн салалтын дараах** "Хүүхдийн тэтгэлгийн сан"-г байгуулах саналыг АЭХ гаргав.  
**ҮХ-ийн өөрчлөлтийг ИЗНН** ядуу иргэд баян төртэй байх бодлогыг үргэлжлүүлж байна гэв.

**ЭДИЙН ЗАСАГ**  
**Төв банк мөнгөний** бодлогын хүүг 11 хувьд хэвээр хадгаллаа.  
**ОУВС-гийн хөтөлбөрөөр** энэ онд 840 сая ам.доллар Монгол Улсыг чиглэх төлөвтэй.  
**МЕС өнгөрсөн санхүүгийн** жилд 776 сая хонконг долларын орлого олжээ.  
**Топ 20 индекс 0.17 хувиар** буурч, 19650.05 нэгжид хүрсэн байна.



**НИЙГЭМ**  
**Борооны улмаас эвдэрсэн** замуудыг Засгийн газрын нөөц хөрөнгөөр засварлана.  
**МУ бусад эрхтнүүдийг** гэмтээхгүйгээр хорт хавдрыг эмчлэх туяаны аппараттай болов.  
**БЗД-ийн 22 дугаар хороонд** хур хогийн цэгийг зайлуулан, сагсны талбай байгуулав.  
**Ээжийгээ бие засах хойгуур** нэг настай хүүхэд голд унаж нас баржээ.

**ДЭЛХИЙ**  
**Facebook-ийн криптовалютад** хатуу зохицуулалт шаардлагатайг Британи анхааруулав.  
**БНХАУ-ын Чиндао хотод** 5G холболттой автобусны шугам ашиглалтад орлоо.  
**Малайзын МНЗ70 дугаартай** онгоцыг нисгэгч санаатай сүйрүүлснийг илрүүлээ.  
**Калифорнийн ойн түймрийн** буруутан Pacific Gas & Electric-ийг \$ тэрбумаар торгов.

## ЦАГ АГААР

**УЛААНБААТАР**  
2019.06.20

☀️ ☁️  
30° 16°  
ҮҮЛШИНЭ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЖИЙГ ҮЙ МЭГЭЭДЛИЙГ ӨДӨЛТӨР НУУРЭЭС УНШИВНА УУ.

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

# Хурган дарга нарын мөнгө цохих шинэ суваг "шар хаалга"



Баянгол дүүргийн II, IV хорооллын замын голын тусгаарлах зурваст нэг тэрбум төгрөгөөр "гэрэлтүүлэгтэй гарц" барьж байна. Бороо, салхинаас хоргодох боломжгүй, харин ч нурж ирээд, дарж алчихмаар эдгээр байгууламж чухам юунд хэрэгтэй вэ. ▶ 3

## ЗГМ: ЗОЧИН

### Т.Үйтүмэн: Хүүгээ бокс руу орчих болов уу гэж бодсон чинь жүдо барилдана гээд байна

**Б.Баярсайхан** @bayarsaikhanZGM

тамирчны өнөр бүлд багтсан хүн бүрийн хувьд энэ бол хүсэн хүлээдэг баяр нь. Энэхүү өдрийг тохиолдуулан **Монгол Улсын гавьяат тамирчин Т.Үйтүмэн**г сонинхоо зочноор урьж ярилцлаа.

-Тантай уулзалгүй их уджээ. Сүүлийн үед хийж буй ажлаасаа сонирхуулаач?  
 -Би яахав, хувь, хувьсгалын ажлаа амжуулах гээд гүйж л байна. Боксын холбооны дэд ерөнхийлөгч гэдэг угтаараа хэдэн тамирчиндаа тусалчих юмсан гээд хийх ажил ихтэй. Уг нь клуб нээж, хүүхдүүдтэй ажиллах санаа байдаг. Яг зориглоод бариад авъя гэхээр амжихгүй юм.

## ЗГМ: ИНФОГРАФИК

### САВЛАСАН УСАН ДАХЬ БИЧИЛ ХУВАНЦРЫН АГУУЛГА

ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ЛОНХОЛСОН УСНЫ АЛДАРТАЙ БРЭНДИЙН 93 ХУВЬ НЬ БИЧИЛ ХУВАНЦРЫН АГУУЛГАТАЙ.

БРЭНД	ҮЙЛДВЭРЛЭГЧ	ТЕСТЭЛСЭН УЛС	БИЧИЛ ХУВАНЦРЫН АГУУЛГА
Nestle Pure Life	Nestle		6-10,390
Bisleri	Bisleri International		0-5,230
Geroisteiner	Geroisteiner Brunnen		9-5,160
Aqua	Danone		0-4,713
Epura	PepsiCo		0-2,267
Aquafina	PepsiCo		2-1,295
Minalba	Grupo Edson Queiroz		0-863
Wahaha	Hangzhou Wahaha Group		1-731
Dasani	Coca-Cola		2-335
Evian	Danone		0-256
San Pellegrino	Nestle		0-74

325 Худалдааж буй литр усан дахь бичил хуванцрын дундаж тоо

**Тайлбар:** Дэлхийн есөн улсын зах зээлд түгээмэл зарагдаж буй 11 брэндийн лонхолсон усны литр тутамд оногдох бичил хуванцрын агуулга. Ундны усан дахь бичил хуванцарт полипропилен, нейлон, полиэтилен терефталат багтаж байна.

ДЭМБ, Forbes, ORB Media

## НИЙГЭМ

### Хүчирхийлэгчийг мэдээлж, ЗОВСОН НЭГНЭЭ ХАМГААЛЪЯ

**Б.Бадамцэцэг**  
ЗГМ

Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн хүн амины хэргийг шүүх хурал өчигдөр болов. Гурван жилийн турш эхнэрээ айдас, хүчирхийлэлд байлгаж, эцэст нь амийг нь хөнөөсөн эрд 18 жилийн ял оноолоо. Амиа алдсан бүсгүйн охин хохирогчийг төлөөлж шүүх хуралдаанд оролцохдоо "Ээжийн минь амийг хөнөөсөн энэ хүнд үгээр хэлэхийн аргагүй гомдож байна" гэж хэлээд мэгшгэл үйлсэн. Харин гартаа гавтай 50 орчим насны эр унжийн сулдаж, хөшсөн мэт зогсож байлаа. Эмэгтэй хүнд эр бяраа гаргаж, бах таваа ханган хүчирхийлж байхдаа ямар царайтай байсан бол гэж бодохоос жигшил төрнө. Нэг нь шоронд орж, нөгөө нь шоронд булагдсан аймшигт энэ хэргийн золиосонд гурван хүүхэд "тэжээгчээ алдсаны тэтгэмж"-ээс өөр юу ч үгүй хоцров.

Гэр бүлийн хүчирхийлэл гурван янзын л төгсгөлтэй гэнэ. Эхний тохиолдолд хэн нэг нь гэмтэж, бэртэнэ. Дараагийнх нь гэр бүл сална. Эцсийн бүлэгт эхнэр, эсвэл нөхрийн аль нэг нь амиа алдана. Өнөөдрийн байдлаар эмэгтэйчүүдийн хорих ... дугаар ангид 300 орчим эмэгтэй ял эдэлж байна.

АЛТ	ЗЭС	10-ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ
1342.35 0.32%	5949 1.78%	98.700 0.13%	110.70 0.12%	99.330 0.12%	2,652.13	383.83	40.78



## Цаг үе

Аймаг, сумын дарга нар хаалга барьж мөнгө цохидог бол нийслэл дүүргийнхэн бродюр солих замаар ашиг унагадаг арга нэгэнт ил болсон. Тэгвэл төсвийн хөрөнгөнөөс цохих шинэ арга сэдэж олсон нь энэ төмөр сараалж бололтой.



Ж.Гэрэлчулуун / ЗГМ

# Хурган дарга нарын мөнгө цохих шинэ суваг “шар хаалга”

**Тэрбум төгрөгийн “бүтээн байгуулалт”-ыг нураахдаа тулбал хэн хариуцлага хүлээх вэ**

Г.Санжааханд  
@sanjaakhandZGM

Ердөө хэд хоногийн өмнө төв замуудын голоор татсан шар хашааны “паян” дуусаагүй байхад гарцан дээгүүр хаалгаар шинэ “сюрприз” барилаа. Баянгол дүүргийн гурав, дөрөвдүгээр хорооллын замын голын цэцэрлэгт байгууламжид барьж буй улбар шар зүйлийг хаалга гэхэд ч хаашаа юм. Тус дүүргийн Засаг дарга С.Одонтуяагийн хэлснээр “гэрэлтүүлэгтэй гарц” гэж энд нэрлэе.

Гэхдээ нийтлэлийн агуулга нэрэнд биш, харин тэр улбар шар өнгөтэй, төмөр гарц хотын иргэдийн тав тухыг хангахад ямар үүрэгтэй вэ гэдэгт байна. Замын гарцны гэрлэн дохио нь ажиллаж, цагаан шугам нь

харагдаж л байвал хэрэгцээ шаардлага хангах биш үү. Хоёр урсгалт зам хоорондох тусгаарлах зурваст шөнөдөө гэрэлтдэг тод өнгийн төмөр карказтай төстэй рам босгосноор иргэд гарцаа олж гарах ач холбогдолтой гэж Тээврийн цагдаагийн газраас мэдээлэл хийх вий. Бороо, салхинаас хоргодох ч боломжгүй, харин ч нурж ирээд, дарж алчихмаар эдгээр байгууламж чухам юунд хэрэгтэй вэ.

Эдгээр асуултдаа хариулт авахаар холбогдох албаныхнаас тодруулав. Юуны түрүүнд энэхүү ажилд нийслэлийн төсвөөс нэг тэрбум төгрөг зарцуулж буй гэдэг баримтыг авлаа. Энэ бол Арьс ширний үйлдвэрийн 20 айлын байрыг нураагаад, 40 айлын орон сууц шинээр барихаар төсөвлөсөнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгө.

“Сайн констракшн” компани энэ мөнгөний гүйцэтгэлд дээр дурдсан гэрэлтүүлэгтэй гарцыг хийхээс гадна зарим автобусны буудлыг тохижуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. Түүнчлэн хогийн сав, чулуун сандал зэргийг байршуулж, замын хоёр талд сараалжин хашаа

хийхээр төлөвлөсөн гэдгийг тус компанийн ажилтан Ж.Эрдэнэбат ярилаа. Мөн “Байгаль эх” хөшөөт цогцолборыг шинэчилж, усан оргилуур бий болгох аж. Сонсоход их ажил мэт боловч зун бүр л нийслэлийн гудамж, талбайд хийдэг урсгал засвар, тохижилт үйлчилгээ биш гэж үү.

● **Нэг тэрбум төгрөг бол Арьс ширний үйлдвэрийн 20 айлын байрыг нураагаад, 40 айлын орон сууц шинээр барихаар төсөвлөсөнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгө.**

● **Хэний ямар шалгуураар, хаанаас гаргасан зураг төслөөр үүнийг хийхийг зөвшөөрчихөв.**

● **Нийслэл нь дүүрэг рүү, дүүрэг нь эргээд нийслэлд нялзааж байгаа энэ ажлын ард “но” байгаа учраас бие бие рүүгээ түлхэж, цэвэр үлдэхийг хүсэж буй нь сонирхол татаж байна.**



Хэний ямар шалгуураар, хаанаас гаргасан зураг төслөөр үүнийг хийхийг зөвшөөрчихөв. Гудамжны өнгө үзэмжийг лав л чимсэнгүй, харин ч гутааж байна. Өнгөний хувьд ч, хэлбэр хийцийн талд ч тэр. Дэлхийн улс орнуудын томоохон хотууд, тэр дундаа нийслэлд өнгөний код гэж бий. Ямар ч бүтээн байгуулалт тэрхүү кодчилсон загварыг шингээж батлуулдаг жишигтэй. Харин манайд хэн дуртай нь санаанд орсон өнгө загвараараа

хотоо “чимдэг” бололтой.

Нийслэлийн дунд түвшний хурган дарга нар сонгуульт хугацаа нь дуусахаас өмнө амжиж мөнгө “идэх” гэсэн шахаа нь элдэв өнгийн хаалт, хашилт, хаалгаар илэрч байна гэсэн хардалт өөрийн эрхгүй төрнө. Тэд үлдсэн хугацаандаа үүнээс ч илүү “сюрприз” барихаар төлөвлөж байгаа даа гэхээс дотор харанхуйлж байна.

Аймаг, сумын дарга нар хаалга барьж мөнгө цохидог бол

нийслэл дүүргийнхэн бродюр солих замаар ашиг унагадаг арга нэгэнт ил болсон. Тэгвэл төсвийн хөрөнгөнөөс цохих шинэ арга сэдэж олсон нь энэ төмөр сараалж бололтой.

Энэ талаар Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын Барилга захиалагчийн хэлтсийн хяналтын инженер Б.Ариунбат “Баянгол дүүргээс асуу. Нийслэлд хамаагүй. Манайх зөвхөн хяналт тавьж байгаа” гэсэн бол харин Баянгол дүүргийн Төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналт шинжилгээний хэлтсийн дарга Ө.Мөнхчулуун “Манай нутаг дэвсгэр дээр хийж байгаа болохоос биш нийслэлийн төсвөөр барьж буй ажил. Баянгол дүүрэг санаачлан хийсэн бол дүүргээс төсөв гаргах байсан” гэх хариултыг өгсөн юм. Нийслэл нь дүүрэг рүү, дүүрэг нь эргээд нийслэлд нялзааж байгаа энэ ажлын ард “но” байгаа учраас бие бие рүүгээ түлхэж, цэвэр үлдэхийг хүсэж буй нь сонирхол татаж байна. Аль нэг төсвийн байгууллагаас мөнгө гаргасан учраас л урдаас оруулж ирсэн улбар шар төмрүүдээ угсарч эхэлсэн байлтай.

Ер нь нийслэл, дүүргийн дарга нарын мөнгө цохих арга нь агаарын бохирдолтой тэмцэх, замын бродюр солих, хашлага, тохижилтын ажил гэх мэт хэдэн сувгаар урсдаг. Харин одоо гарцан дээрх хаалга нэмэгдэж байгаа бололтой.

720 орчим сая төгрөгөөр барьсан шар хашаанууд ганц шуурганы ая даахгүй нурж унан, тараа таниулсан. Түүний өмнө замын зарим уулзвар дээр хааж тавьсан хуванцар хаалт энгийн салхинд хийсч унаад байсан тул тоосгоор дээр нь даруулж, торгоосон нь одоо ч хэвээр. Халуунд хайлаад гулзайчихдаг, өвөл нь хөлдөөд хагарчихдаг замын голын шонгууд бас л үүний жишээ. Гэрэлт гудамжийг будсан шатрын хөлөг борооны дараа арилчихсан хөг ч бий.

Нийслэлийн өнгө үзэмжийг сайжруулахын төлөө ажил хийх нь зүйн хэрэг. Гэхдээ нэг шуурга, ганц бороог тэсэхгүй юм бол юуных нь тохижилт байх билээ. Жил бүр л III, IV хорооллын замын тусгаарлах зурвас энэ хэсэгт шугамын засвар хийхээр ухааж сэндийчин, иргэд хэрэглээний халуун усаа хаалгаж зусдаг байсан үе саяхан. Тэрбум төгрөгийн “бүтээн байгуулалт” шугамын гэмтлээс болж нураахдаа тулбал хэн хариуцлага хүлээх вэ. Гүйцэтгэгч компаниас энэ эрсдэлийг тооцож үзсэн эсэхийг асуухад “Тийм зүйл болохгүй” гэх товчхон хариулт өгсөн юм.

Харин ч илүү ажил, нэмэлт хөрөнгөөр засаж сэлбэх шаардлага гардгийг эрх биш ойлгодог баймаар. [ЗГМ]

## С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА









# ZGM DAILY

## BoM leaves interest rate steady at 11 percent

A sharp change in the price of meat triggered by the price of petroleum.

## Mongolia Energy Corporation earns HKD 776.7 million

The gross profit ratio dropped from 49.5 percent to 43.2 percent.

## U.S.-based firm to invest in MCS LLC

The company seeks to buy the food and communication businesses owned by MCS.

## Top 20 index drops 0.17 percent to 19,650.05 points

Market cap stands at MNT 2,46 trillion.

### ZGM: HIGHLIGHTS

#### POLITICS


Mongolian delegation led by Ambassador Extraordinary and Plenipotentiary of Mongolia to Tajikistan participates in the fifth summit of the Conference on Interaction and Confidence Building Measures in Asia (CICA) held in Dushanbe, Tajikistan.

#### ECONOMY

Achit Ikht LLC listed on the London Metal Exchange allocates its third-quarter dividend. The company has paid MNT 140 billion for taxes and fees to the state and local budget last year.

The Erdene Resource Development Corp, listed on Toronto and Mongolian Stock Exchange, plans to hold an annual meeting on June 20 in Canada.

Top 20 index drops 0.17 percent to 19,650.05 points. MSE A index increases 2.35 percent to 8,991.47 points. MSE B index up 0.71 percent to 7,894.53 points. Market cap stands at MNT 2,46 trillion.



#### SOCIETY

Awards were presented to the Mongolian soldiers who successfully served in international peacekeeping operations on June 18. Specifically, a ceremony to award the peacekeepers of the ninth batch took place at the General Staff of the Mongolian Armed Forces (GSMAF).

Eleven servants from the National Emergency Management Agency (NEMA), National Rescue Brigade and the Emergency Management Departments in Bayan-Ulgii, Gobi-Altai, Zavkhan, Khovd, and Uvs provinces participate in mountain rescue operations taking place in Bishkek, the Kyrgyz Republic.

Men's 3x3 basketball team wins the Russian team at the 2019 FIBA 3x3 World Cup.

# BoM leaves interest rate steady at 11 percent



The decision to retain the BoM rate included the macroeconomic situation of Mongolia, further outlook, uncertainty, and external risks.

## BoM names loans in the banking system as downside factor to economy

Aminaa.U  
ZGM

The monetary policy committee of Bank of Mongolia (BoM) announced to leave the interest rate at 11 percent yesterday. The decision to retain the BoM rate included the macroeconomic situation of Mongolia, further outlook, uncertainty, and external risks.

The Deputy Governor of the

BoM said "Considering the external economic environment and internal activism, inflation is likely to stabilize at the target level. Annual inflation in May reached 7.9 percent nationwide. A sharp change in the price of meat triggered by the price of petroleum over the global price swing in oil were the key factors in inflation, while the demand for basic inflation remains steady. The economy is growing as the mining sector exceeds expectations in the first quarter of this year, steadily increasing business lending, increasing investment, and budget spending. The global trade crisis has been deepening over the past month. In addition, the United States and China have increased their import tariffs for

some commodities, creating a risk for global economic growth, commodity prices, and increasing external uncertainty."

The decline in foreign trade overlaps with large mining projects and the repayment of heavy foreign debt repayments. Therefore, analysts highlighted the importance of directing the domestic and external balance of macroeconomic policies and to increase the accumulation of country, community, organization, household, individual and financial sources.

"Ensuring the stability of foreign investment will directly impact the economy. As for the policy environment, the monetary policy went on to support economic growth last

- The decline in foreign trade overlaps with large mining projects and the repayment of heavy foreign debt repayments.

- Ensuring the stability of foreign investment will directly impact the economy.


- The recent two-year monetary policy was to move towards today's interest rate growth.

year. However, the fiscal policy has taken measures to stabilize the economy, but from the middle of last year, it has been working set on promoting economic growth. We are keeping the same policies for this year. The recent two-year monetary policy was to move towards today's interest rate growth," remarked a spokesperson of the BoM.


He added that the key factor that is affecting the economy is the loan in the banking system. The overall loan rose 19.7 percent in May compared to the previous year. Investment-related business credits grew by 17 percent since the fourth quarter of 2018. Consumer loan, on the other hand, has fallen to 34 percent, boosting growth in business lending. [ZGM]

### STOCK MARKET


**Ard Daatgal JSC**  
(One month to date)



**BDSec JSC**  
(One month to date)



**Gobi JSC**  
(One month to date)



### MINING

## Mongolia Energy Corporation earns HKD 776.7 million

Mongolia Energy Corporation (MEC)'s revenue rose 21.9 percent to HKD 776.7 million in the fiscal year of March 2019.

During the period, MEC sold about 600,000 tons of washed coking coal and 78,000 tons of thermal coal. The company, which operates in Khushuut deposit, sold coking coal at HKD 1293 per ton and thermal coal at HKD 45.3 last year. Total profits rose slightly to HKD 440 million. However, the gross profit

ratio dropped from 49.5 percent to 43.2 percent. This is mainly due to increased sales costs. Expenses increased as sales and transportation costs rise.

MEC owns nine operational licenses and two explorational licenses. The company's shareholders meeting is scheduled to be held on August 27. However, the board advised not to distribute dividends from the previous fiscal year. [ZGM]

## Xanadu Mines to raise additional AUD 3.37 million

Xanadu Mines, listed on the Australian Securities Exchange (ASX) and operates in Mongolia, is planning a seasoned issue worth AUD 3.37 million.

These non-transferable shares are only available to be purchased by current shareholders. The price per share will be valued at AUD

0.052. Shareholders will be able to purchase a share for every 10 shares they own. The funds will be spent on continue drilling work to explore the Red Mountain project under the Kharmagtai project. At the end of the first quarter, the cash balance stood at AUD 3.1 million, according to the company's report. [ZGM]

### MARKETS

## A US-based firm is in talks to buy stake in MCS

Cerberus Capital Management LP, which is based in New York, is discussing to buy 25 percent of the MCS Group LLC for USD 110 million, according to the Wall Street Journal. The company seeks to buy the food and communication businesses owned by MCS. Investing in Mongolia is under the responsibility of Cerberus Frontier's Singapore branch, which is dedicated to investing in emerging markets.

Cerberus Capital Management LP is a large company with a large equity share of Deutsche Bank AG and Avon Products Inc., with total equity of USD 39 billion, the WSJ reported.

The journal also named Mongolia as "a challenging place to invest because of volatility in economies, currencies and politics".

"Mongolia has a "boom-to-

rust" track record in attracting foreign investment, according to a World Bank report published last year. Foreign direct investment hit a record USD 4.5 billion in 2011 fueled by a rapid expansion of the landlocked nation's mining sector. Investment later fell as commodity prices slumped," wrote the journal.

In recent years, foreign investors are paying keen attention to Mongolia. For example,

South West's Barloworld Group placed a bid to buy the Wagner Asia Group, a mining equipment supplier. "The key risks of the companies investing are to investigate and assess the challenges in Mongolia. On the other hand, Barloworld is a company with experience in political instability in developing countries," Kelvin Kaukinen, Executive Director of Wagner Asia Equipment LLC. [ZGM]

### FINANCE

## BoM: USD 840 million scheduled under EFF this year

Under the Extended Fund Facility, Mongolia drew USD 17 million from the International Monetary Fund (IMF) and other donors in 2017-2018. The program, which completed the sixth phase review, is currently awaiting the IMF board decision to step up the plan, in which another USD 840 million is scheduled this year according to the Bank of Mongolia (BoM). The BoM reported that the overall financing from the program totaled USD 400 million last year. The IMF pointed out that a "strong banking sector, disciplinary budget, and monetary policy are important to ensure the current results." [ZGM]









### Эдийн засаг

# Д.Трампа гомдол дүүрэн үгсээр сонгуулийн сурталчилгаагаа эхлүүлэв

Женнифер Жакобс

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп мягмар гарагт дахин сонгогдох сурталчилгааны кампанит ажлаа албан ёсоор зарлаж, гомдол дүүрэн үг хэлэхдээ 2020 онд түүний өрсөлдөгчид ялбал Америкийг бүүдгэр ирээдүй хүлээж байна хэмээн анхааруулаа. Тэрээр Флорида муж улсын Орlando хотод хэлсэн үгэндээ “2020 онд Ардчилсан Ерөнхийлөгч, Ардчилсан конгресстэй байна гэж бодоод үз дээ. Тэд үг хэлэх эрх чөлөөг хавчина. Сөрөг талыг хуулийн хүчээр шийтгэх эрх мэдлээ одоогийнх шигээ ашиглах болно” хэмээв.

Ерөнхийлөгч цааш нь “Тэд улс төрийн хүрээгээ өргөтгөхийн тулд хууль бус цагаачдыг оруулж, америкчуудын үндсэн хуулийн эрхийг хазарлах болно” гэжээ. Ширүүн бороо орсон авч Орландогийн Amway төвд болсон цуглаанд олон мянган дэмжигч цугласан байв. Трампын сонгуулийн менежер Брэд Парскейл, Трампын хүү Эрик болон албаны хүмүүс идрээс үг хэлжээ. Сонгуулийн сурталчилгааны хэвлэлийн төлөөлөгч Тим Мартоугийн хэлснээр мэдээллийн эрх авах 1200 хүсэлт ирсэн нь өмнөхөөс найм дахин нэмэгдсэн байна.

Ноён Трамп 40 минут үргэлжилсэн үгэндээ “Өнөө орой би АНУ-ын Ерөнхийлөгчөөр хоёр дахь хугацаанд сонгогдохоор сурталчилгаагаа эхлүүлж буйгаа зарлахаар та бүхний өмнө зогсож байна” хэмээн мэдэгдэв. Түүний сурталчилгаа хүчтэй эдийн засаг, албан тушаалдаа байгаа болон баян тогтмол хандивлагчдын дэмжлэгтэй байгаа нь түүхэн үүднээс харвал дахин сонгогдох таатай урьдчилсан нөхцөл юм. Гэвч янз бүрийн зөрчил, хэт барууны чиглэл зэрэг нь иргэдийн дэмжлэгийг 40 хувь болтол доошлуулсны дээр зүүний



талынхны зэвүүцлийг төрүүлсэн тул 2020 оны сонгуульд сонгогчид урьдахаас олноор саналаа өгөх боломж үүсгэж буй.

Ийм нөхцөлд Ерөнхийлөгч

цагаачлалын айдас, Вашингтон ба АН-ын эсрэг үзэлд дөрөөлөн иргэдийн саналыг татах оролдлого хийх нь тодорхой харагдлаа. Бүгд найрамдах намын нэг

удирдагч Франк Лунц “Түүнийг дэмждэггүй хүмүүс Трампад үнэхээр дургүй. Тэр өөрөө ч эсэргүүцэгчдийг талдаа татах талаар олигтой юм хийгээгүй.

Харин түүнд дуртай хүмүүс өнөөдөр түүнд бүр хайртай болсон” хэмээв.

Ноён Трамп 2016 оны сонгуульд Оросын талаас оролц-

сон гэх асуудлаар мөрдөн байцаалтыг удирдсан тусгай зөвлөх Роберт Мюллерийн талаар дахин гомдоллож, үүнийг “Манай ардчиллыг хөнөөх” гэсэн Ардчилсан намын хуйвалдсан хэмээн нэрлэв. Түүнчлэн “Энэ сонгууль бол ялагсаа хүмүүс түүнийгээ хүлээн зөвшөөрөхөөс татгалзан, дараагийн хоёр жилд нь үндсэн хууль хийгээд улс орныг тасчих гэж оролддог тийм оронд бид амьдрахыг хүсэж байгаа эсэх шалгуур болно” гэж мэдэгджээ.

Трампын сурталчилгаа АНУ-ын эдийн засгийг сэргээхэд түүний үүргийг дөвийлгөх, Ерөнхийлөгч цагаачлал, уур амьсгалын гэрээ, Ираны цөмийн асуудал зэрэгт өгсөн амлалтдаа эзэн болдог гэсэн мессеж түгээхэд чиглэгдэж байна. 2016 онд Трампын сурталчилгааны зөвлөх байсан, одоо ч түүнд ойр байгаа Дэвид Урбан “Та дургүй байлаа ч тэр хэлсэн бүхнээ гүйцэтгэхийн төлөө явдаг хүн. Өөр олон зүйл хийх ёстой бөгөөд энэ нь түүнд хоёр дахь хугацаа өгөх шалтгаан юм. Түүнд эхэлснээ гүйцээх боломж олгое” хэмээн уриалжээ.

Трамп “АНУ одоо өсөн дэвжиж, цэцэглэж байна. Шуудхан хэлэхэд тус улс итгэмээргүй өндөрлөг рүү хөөрч байгаа. Манай эдийн засаг дэлхий дахины атаархлыг төрүүлж, магадгүй бид одоо түүхэн хамгийн хүчирхэг эдийн засагтай байна” хэмээн тунхаглав. Цагаачлал Трампын засаглалын үед иргэдийг хамгийн их туйлшруулсан сэдэв болсон. Цагаан ордын зөвлөхийн хэлснээр уг асуудал Трампыг дэмжих эсвэл эсэргүүцэх нэг номерын асуудал болжээ. 2018 онд Трамп цагаачлалыг дунд хугацааны сонгуулийн сурталчилгааны төвд тавьсан боловч БНН төлөөлөгчдийн танхим дахь олонхоо алдсан юм. Түүнчлэн Мексикийн хил дээр хана барих тухай дуулиантай санал нь хэрэгжээгүй байна.

## Цахилгаан онгоц анхны байнгын нислэгт гарахаар бэлтгэж байна

Тара Пател

Цахилгаан машины Eviation Aircraft компани саяхан анхны хэрэглэгчтэйгээ гэрээ байгуулсан авч ойрын хэдэн жилд захиалагчдын эрэлтийг хангаж чадахгүйд хүрэх байх гэж шинжээчид таамаглажээ. Компанийн ерөнхий захирал Омер Бар-Юхей Парисын агаарын шоуны үеэр өгсөн ярилцлагадаа Cape Air компанид хоёр оронтой тоогоор хэмжигдэх хэмжээний онгоц худалдах болсноо мэдэгдэв. Cape нис-

лэгийн оператор 88 Cessna турбо онгоц ашиглан Бостон, Нью Йорк, Наттукет зэрэг чиглэлд нислэг үйлддэг аж.

Eviation-ы бүтээсэн Alice загварын онгоцыг анхнаас нь цахилгаан мотортой байхаар дизайныг хийсэн агаад нэг удаагийн цэнэгээр есөн зорчигч авч, 650 бээр алсад нислэг хийх хүчин чадалтай юм. Энэ онгоц хөнгөн онгоцны

тээврийн үйлчилгээний зах зээлд эргэлт авчирч магадгүй байна. Онгоцны хүлэмжийн хийн ялгаруулалтыг шүүмжлэх хандлага нэмэгдэж буй үед агаарын тээврийн салбарт цахилгаан онгоцны сонирхол эрс өсөөд буй. Тус компани АНУ-д энэ оны сүүлээр анхны нислэгээ хийх ба Аризона, Вашингтонд угсрах үйлдвэрээ өргөтгөж,

2021 онд сертификат авахаар төлөвлөжээ.

Ноён Бар-Юхей “Бид түүрүүлж яваа ч бусад компани араас нэхэж буйг ойлгож байна. Онгоцыг үйлдвэрээс гаргах нь бэрхшээлийн дөнгөж эхлэл. Түүнд хамаатай бүх зүйлийг хийх хэрэгтэй. Бидэнд онгоцыг дэмжих орчин, инженер,

техникчдийн сургалт шаардлагатай” хэмээсэн юм. Түүний хэлснээр Cape Air цэнэглэх ба засвар үйлчилгээний дэд бүтэц барих аж. Eviation-ы нэг давуу тал нь нислэгийг өртөг гэдгийг захирал онцолжээ. Alice-ийн нэг цагийн нислэг 200 ам.доллар бол турбо онгоцных 1000 байгаа.

Гэвч Alice энгийн

онгоцноос удаан буюу дээд хурд нь цагт 240 бээр агаад энэ нь орчин үеийн бизнес ангиллын тийрэлтэт онгоцны хурднаас хоёр дахин бага боловч турбо онгоцноос нэг их дутахгүй. Израилын нийслэлийн ойролцоох Кадима хотод төвтэй Eviation 2015 онд нислэг ба технологийн мэргэжилтнүүдийн хамтын хүчээр байгуулагджээ. Одоо эрдний дэлхий даяар 100 орчим цахилгаан онгоцны хөтөлбөр хэрэгжүүлж байна. Roland Berger зөвлөх фирмийн тооцоогоор энэ нь 2017 оноос 30 хувь өссөн үзүүлэлт юм.



## Азийн бондын зах зээлд ил тод байдал түр нэвтэрлээ

Анни Ли

Сүүлийн жилүүдэд Азид долларын бондын зах зээл түргэн тэлсэн явдал олон улсын хөрөнгө оруулагчдын дунд бонд гаргагчийн танилцуулга бүрхэг, Хятадын худалдан авагчид ноёрхдог гэх мэт янз бүрийн яриа шүүмжлэл үүсгэсэн. Олон улсын капиталын зах зээлийн Азийн хороо байгууллага өнгөрсөн сард менежерүүдэд хандаж, бондын арилжааны өөрийн захиалгыг ил болгох шаардлага тавьсныг учир мэдэх эх сурвалж мэдээлэв. Тус байгууллага тодорхой журам

батлах асуудлыг хөндөөгүй ч хөрөнгө оруулагчдын түгшүүрийг авч үзсэн юм.

АНУ-д бондын зуучлагчид өөрсдөө арилжаанд оролцохоос татгалздаг бичигдээгүй хууль үйлчилдэг. Үнэн хэрэгтэй зуучлагчийн ажил бол худалдан авагч олох зорилготой болохоос өөрөө худалдан авах явдал биш. Японоос бусад орныг багтаасан Азийн бондын 1.3 их наяд ам.долларын багтаамжтай зах зээлд Хятад зонхилдог агаад цахилгыг ил болгох стандарт журам байхгүй учир зуучлагчид

өөрсдөө бондын зарим хэсгийг худалдан авдаг байх гэсэн сэжиг төрүүлдэг аж. Учир нь бонд гаргагчид худалдсан бондын хэмжээг шалгуур болгон зуучлагчдыг хөндөлдөг тул ийм байдал үүссэн байж болзошгүй.

Ингэснээр арилжаа дууссаны дараа үнэ огцом унаж, бусад худалдан авагчдад хохирол учруулах нөхцөл бий болдог байна. Өнгөрсөн онд өндөр өгөөжтэй зарим бондын арилжаан дээр ийм байдал ажиглагдсан. Income Partners хөрөнгийн менежментийн фирмийн ажилтан Жеймс Ху

“Зуучлагч менежерүүдийн ажиллагааг ил болгох нь бидэнд бондын зах зээлд оролцох боломжийг илүү таатай болгоно. Сүүлийн жилүүдэд Хятадын ам.долларын бондын хэд хэдэн хэлцэлд зуучлагч банкууд буюу зээлдүүлэгчдэд хамаатай талууд их хэмжээний захиалга өгсөн нь бондын үнийг агшин зуур өсгөж, зах зээлийг тогтворгүй болгосон” хэмээн тайлбарлав.

Дээрх уриалга үр дүнд хүрч буй эсэх нь эргэлзээтэй. Гэвч өнгөрсөн сарын гурванд болсон уулзалтаас хойш хийгдсэн 22 хэлцлийн

аравт нь зуучлагчид өөрсдийн захиалгыг нээлттэй болгосон нь ил тод байдлыг дэмжсэн хандлага гэж шинжээчид үзэж байна. Ноён Ху “Ийм тайлангийн үнэн зөвийг шалгахад бэрхшээлтэй. Бас ил тод байдал нь заавал хэрэгжүүлэх журам бус. Энэ нь мэдээлэл нийтлэхэд нэг талыг барьсан хандлага үүсгэж болзошгүй. Тухайлбал, зөвхөн олон төрөлтэй захиалгын мэдээллийг ил болгодог хандлага гарна” хэмээн анхааруулаа.

Сингапур дахь Nikko хөрөнгийн менежментийн фирмийн ажилтан Леон Хун “Илүү ил тод байдлын

тухай шинэ журам баталбал хөрөнгө оруулагчдад бодит эрэлтийг үнэлэх боломж олгож, шударга үнэ тогтооход тусална. Харин одоо худалдан авагчид үүний төлөө тэмцэх хэрэгтэй” хэмээн сануулав. Түүнчлэн өрийн зах зээлийн мэргэжилтэн Ионн Вон “Ил тод бус байдал зах зээлийн журмыг дагадаггүй зуучлагч менежерүүдэд хортой байж болзошгүй. Учир нь мэдрэмжтэй бонд гаргагчид тэднийг сонгохгүй бөгөөд хөрөнгө оруулагчид тэднээс худалдан авахгүй” хэмээн тайлбарлажээ.

## Эдийн засаг

### МӨНГӨНИЙ БОДЛОГО



С.Батсайхан / ЗГМ©



# Бодлогын хүүг хэвээр үлдээв

**Эрсдэлээс сэргийлэн, санхүүгийн нөөцөө нэмэгдүүлэх шаардлагатай**

Г.Илч  
ЗГМ

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 11 хувьд хэвээр үлдээлээ. Нийлүүлэлтээс үүдсэн инфляц эрчимжиж, төгрөгийн ханш суларсан тул мөнгөн тэмдэгтийн ханшийг хамгаалахын тулд ийн шийдсэн болохоо төв банкны бодлого тодорхойлогчид онцолж байна. Макро эдийн засаг сэргэсэн хэвээр байгаа ч АНУ, Хятадын худалдааны дайн гүнзгийрсэн нь гадаад зах зээлийн эрсдэлийг нэмэгдүүлсэн. Энэ нь дэлхийн эдийн засгийн өсөлт болон түүхий эдийн эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа аж.

Гадаад зах зээлд таамаглахад амаргүй, тодорхой бус байдал хүрээгээ тэлэхээр байгааг төв банкнаас анхааруулж байна. Худалдааны дайн үргэлжлэх магадлал өндөр байгаатай



зэрэгцээд манай улсын гадаад худалдаа буурах, өндөр үнийн дүн бүхий эргэн төлөлт хийх хугацаа давхцаж байгаа аж. Тиймээс макро эдийн засгийн бодлогыг өндөр өсөлт, эдийн засгийн идэвхжилээс илүү эрсдэлээс сэргийлж, гадаад, дотоодын тэнцвэрийг хангахад чиглүүлж, улс, аймаг орон нутаг, байгууллага, өрх айл, бизнес эрхлэгчид хуримтлалаа өсгөж, санхүүгийн нөөцөө нэмэгдүүлэх шаардлагатай төв банкны Мөнгөний бодлогын хорооны шийдвэрт дурдсан байна.

Мөн гадаад орчны болзошгүй эрсдэлийг хохирол байгаатайгаар даван туулж, эдийн засгийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад төсвийн сахилга бат, банкны салбарын эрсдэл даах чадвар, төв банкны бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлэх нь чухал байна хэмээн Монголбанкны дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн мэдэгдсэн юм.

Өнгөрсөн сарын байдлаар инфляцын түвшин 7.9 хувьд хүрсэн. Үүний 40 хувийг мах, шатахуун түлш зэрэг нийлүүлэлтээс үүдсэн өсөлт бүрдүүлснийг Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа мэдэгдсэн юм. Гэтэл төв банкны мөнгөний бодлогын арга хэрэгслүүд нь

эрэлтээр дамжин, инфляцад нөлөөлдөг. Хэрэв нийлүүлэлтийн шалтгаантай инфляцыг эрэлтийн шалтгаантай арга хэрэгслээр удирдвал энэ нь эргээд инфляцыг илүү эрчимжүүлэх эрсдэлтэй.

### Төв банкны бие даасан, хараат бус байдлыг нэмэгдүүлэх нь чухал

Тиймээс Засгийн газар махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай гэсэн байр суурьтай байна хэмээн Төв банкны Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтсийн захирал Н.Ургамалсувд мэдэгдэж байсан юм. Гэхдээ энэ оны эцэст хэрэглээний үнийн индекс 7-8 хувьд хэлбэлзэнэ гэж төв банк таамаглаж байна.

2019 оны эхний улирлын байдлаар ДНБ-ий өсөлт сүүлийн жилүүдийн дээд цэгт буюу 8.6 хувьд хүрсэн. Харин энэ оны эцэст эдийн засгийн өсөлт 7.9 хувьд хүрэх бол ирэх онд удааширч, зургаан хувьд хүрэх төлөвтэй байна. [ЗГМ]

### ЗГМ ТОВЧХОН

» ҮЙЛДВЭРЛЭЛ

3.4

Сая тонн. 2030 он гэхэд дотоодын цементийн хэрэгцээ 2.6 дахин нэмэгдэж 3.4 сая тоннд хүрэх төлөвтэй байна.

» ИМПОРТ

300

Мянган тонн. 2030 он хүртэл жилд 300 мянган арматур импортолно.

» ЭКСПОРТ

600

Мянган тонн. Хөшөөтийн орд энэ онд 600 мянган тонн коксжих нүүрс, 78 мянган тонн дулааны нүүрс борлуулжээ.

» САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

840

Сая ам.доллар. Энэ онд манай улс 840 сая ам.долларын санхүүжилтыг авахаар төлөвлөөд байна. Өнгөрсөн онд 400 сая ам.доллараар тасарсныг Төв банк мэдээллээ.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

621

Мянган ширхэг хувьцаа. Хөрөнгийн биржээр 23 хувьцаат компанийн 180 сая төгрөгийн үнийн дүн бүхий 621 мянган ширхэг хувьцаа арилжлаа.

» ЦАЛИН

12.4

Сая хувьцаа. Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй "Kinross Copper" компани төлөвлөсний дагуу 12.4 сая хувьцааны опционы урамшууллыг ажилчиддаа олгосон байна.

» БИЗНЕСИЙН ОРЧИН

778

Сая хонконг доллар. "Mongolia Energy Corporation"-ий орлого өмнөх оноос 21.9 хувиар өсөж 778 сая хонконг доллар хүрчээ.

» УУЛ УУРХАЙ

3.8

Сая австрали доллар. Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Монгол үйл ажиллагаа явуулдаг "Xanadu Mines" компани 3.8 сая австрали долларын нэмэлт санхүүжилт татахаар боллоо.

» ИНДЕКС

2.5

Их наяд төгрөг. "ТОП 20" индекс 0.17 хувиар буурч 19650 нэгжид хүрсэн бол зах зээлийн үнэлгээ 2.5 их наяд төгрөг боллоо.

### ВАЛҮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,652.13
Евро	2,986.43
Японы иен	24.45
ОХУ-ын рубль	40.78
БНХАУ-ын юань	383.83
БНСУ-ын вон	2.24

### ДЭД БҮТЭЦ

## Эрчим хүчний дутагдлаа дотооддоо нөхөх боломжтой

Н.Анужин  
ЗГМ

Манай улс эрчим хүчний хэрэгцээнийхээ 20 орчим хувийг хоёр хөршөөсөө импортоор авч байна. Монголын эрчим хүчний систем нь Баруун бүсийн, Алтай-Улиастайн, Төвийн бүсийн, Дорнод бүсийн гэсэн дөрвөн хэсгээс бүрддэг. Төвийн бүсийн таван дулааны станц нь 30-55 жилийн насжилттай, нийт тоноглолын 70 гаруй хувь нь элэгдсэн тул манайх шиг улсад ихээхэн эрсдэл дагуулаг аж. Төвийн эрчим хүчний систем дэх нэг гегаватт цахилгаан нь өвлийн цагт хүрэлцдэггүй тул ОХУ-аас нэмэлтээр авахаас өөр аргагүйд хүрдэг.

Тэр дундаа баруун бүсийн хувьд хойд хөршөөс шууд хамааралтай. Сүүлийн үед эрчим хүчний асуудлыг ихээхэн хөндөх боллоо. Шинжлэх ухаан академид "Алтай-Улиастайн эрчим хүчний системийн үр ашгийг дээшлүүлэх арга зам, боломжууд" сэдэвт хэлэлцүүлгийг өчигдөр зохион байгууллаа. Уг хэлэлцүүлгийн үеэр Говь-Алтай аймгийн Тайшир сумаас Есөнбулаг сумыг холбосон 35кВт-ын агаарын шугамыг 110кВт болгож өргөтгөх, мөн Завхан, Говь-Алтай аймгийн хэмжээнд агаарын шугамд холбогдоогүй байгаа сум сууринг холбох ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд үүнд улсын төсөв, холбогдох сайдын

багцаас 15 тэрбум төгрөгийн хөрөнгө төсөвлөсөн талаар ярих. Азидаа хамгийн бага тарифтай, Монголдоо хамгийн их алдагдалтай нь Алтай-Улиастайн эрчим хүчний систем юм. Алтай-Улиастайн эрчим хүчний системийн эх үүсвэрийн дийлэнх нь сэргээгдэх эрчим хүч. Энэхүү ногоон эрчим хүчийг ашиглаж үйлдвэрлэлээ явуулдаг нь агаарын бохирдлыг бууруулахад тустай юм байна. Монголын эрчим хүчний ассоциацийн (МЭХА) ерөнхий нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд профессор Г.Пүрэвдорж "Анхдагч нөөц болох нар, ус, салхи, нүүрсний нөөц хангалттай сайн байгаа боловч үүнийг ашиглан үйлдвэрлэл явуулдаг цахилгаан станцуудын хүчин чадал Монгол улсад хүрэхээ больсон" гэдгийг онцлов. Говь-Алтай, Завхан аймагт үйлдвэр олноор баригдаж байгаа үед эрчим хүчийг хангах асуудал тулгарч байна. Эрчим хүч байхгүй бол үйлдвэр баригдахгүй. Үйлдвэр барих нь эдийн засгийн хамгийн том хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт. Үйлдвэрлэл ихээр барихын тулд эрчим хүчний чадлыг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Эрчим хүчний цаашдын гол чиг үүргийн талаар "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн хэлэхдээ "Хамгийн зөв зохистой эрчим хүчийг үйлдвэрлэж, орчин үеийн



С.Батсайхан / ЗГМ©

технологид суурилсан байдлаар илүү дэвшилтэт хэлбэрээр хэрэглэгчдэд тасралтгүй, найдвартайгаар хүргэхийг зорьж байна. Одоогоор хоёр аймгийг эрчим хүчээр хангадаг. Цаашдаа баруун бүсийг эрчим хүчээр хангах бололцоотой болно хэмээн үзэж байна. Монгол Улс эрчим хүчний дутагдлаас гарахын тулд Говь-Алтай аймагт буй уран, нүүрсний

нөөцөд тулгуурлан үйл ажиллагаа явуулах боломжтой" хэмээв.

Говь-Алтай аймагт коксжуулсан нүүрсний хоёр, чулуун нүүрсний нэг сав газарт зургаан орд, 23 илэрц хүчээр хангадаг. Цаашдаа баруун бүсийг эрчим хүчээр хангах бололцоотой болно хэмээн үзэж байна. Монгол Улс эрчим хүчний дутагдлаас гарахын тулд Говь-Алтай аймагт буй уран, нүүрсний

### ДЦС-УУДЫН СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДЛЫГ ӨВЛИЙН АЧААЛЛЫН ҮЕ (ХУВИАР)

2018		2017
83	ДЦС-2	88
77	ДЦС-3	90
88	ДЦС-4	94
90	ДДЦС	92
97	ЭДЦС	94
68	ЭҮЦДС	-
11	Ухаа худаг	-
90	ТБНС	93


хэлж байв. Мөн дэлхий нийтээр ураны талаар сонирхож байна. Манай улс ч үүнтэй зэрэгцэн ураныг эрчим хүчний салбартаа ашиглах талаар судалгаа хийж эхэлсэн. Байгалийн арвин баялаг нөөцтэй манай улс суурь дэд бүтцээ хөгжүүлвэл эрчим хүчний дутагдлаас богино хугацаанд гарах боломжтой гэж салбарынхан үзэж байна. [ЗГМ]

## Эдийн засаг

### БИЗНЕС ЭРХЛЭЛТ

# Хувцас загвар ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭР рүү алсын хараагаа ЧИГЛҮҮЛЭВ

*Олон улсын байгууллагаас эхлээд гадаадын компаниуд хүртэл манай мал аж ахуйн салбарын ирээдүй, Монгол Улсын экологийн тэнцвэрт санаа зовниж байхад монголчууд бид үүнийг шийдэх дорвитой алхам хийх сөхөөгүй амьдарцаана.*



Г.Байгал  
@baigalZGM

Дэлхийн алдарт брэнд Adidas далайн хуванцар хаягдлаар 11 сая хос спорт гутал үйлдвэрлэх гэж байна. Энэ нь дэлхийн далайн бохирдлыг бууруулах Adidas-ын анхны алхам биш. Тус компани өнгөрсөн онд далайн хуванцар хог хаягдлыг хуримтлуулан дахин боловсруулж, таван сая хос спорт гутал үйлдвэрлэсэн юм. Хэдийгээр дахин боловсруулсан түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүн нь Adidas-ын ашгийг нэмэгдүүлдэг ч тус компани дахин боловсруулсан түүхий эдийн эрэлтээ нэмэгдүүлсээр байна.

Учир нь 2050 он гэхэд далай тэнгисийн хуванцар хог хаягдлын хэмжээ дэлхийн нийт загасны жингээ давах төлөвтэйг McKinsey-ийн тайланд дурджээ. Тиймээс Adidas цэнхэр далайд торох болсон хог хаягдлыг бууруулахын тулд өөрийн хувь нэмрээ оруулж эхэлсэн нь энэ.

Adidas-аас гадна тус компанийн өрсөлдөгчдийн нэг Nike шинэ нэр төрлийн пүүзнийхээ түүхий эдийн 75 хувийг дахин боловсруулсан бүтээгдэхүүнээр үйлдвэрлэж, экологид ээлтэй шинэ загвар брэнд болгохоор зорьж байна. Мөн бэлэн хувцас үйлдвэрлэлээр дэлхийд эхний тавд бичигддэг H&M групп 2030 он гэхэд байгальд хор хөнөөлтэй нэг ч түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй гэдгээ мэдэгдсэн.

Энэ мэт бизнесийн алсын хараа, үйл ажиллагааны чиглэлээ тогтвортой хөгжил рүү чиглүүлсэн хувцас загварын компаниудыг дурдвал дуусахгүй. Сүүлийн зуу орчим жилийн турш хүүхэд эмэгтэйчүүдийг хямд хөлсөөр ажиллуулж, хөдөлмөрийг нь мөхлөж, ус, эрчим хүчийг их хэмжээгээр ашигладаг хэмээн


шүүмжлүүлсээр ирсэн, муу нэртэй хувцас үйлдвэрлэгчид хүртэл өдгөө эрс өөрчлөгдөх болсон. Тэд ажилчдынхаа эрх ашгийг дээдэлж, хүрээлэн буй орчны чиглэлээр боллого зорилт хэрэгжүүлэн, энэ дэлхийн ирээдүйд санаа зовниж буйгаа мэдэгдэх болов.

Учир нь олон жилийн турш эх дэлхийгээ түүхий эд, нөөц авч ашигласаар ирсэн эдгээр компанийн үйл ажиллагаа уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлолтой нүүр тулж, ирээдүй нь ч мухардах болов. Мөн том толгойтой хувцас үйлдвэрлэгчдийг чиглэсэн олон нийт болон төр засгийн байгууллагуудын шаардлага, шүүмжлэл чангарсан нь тэднийг тогтвортой хөгжлийн замыг сонгохоос өөр аргагүйд хүргээд байна. Тиймээс ирэх зуу, зуун жилд үйлдвэрлэлээ таслахгүйн тулд ашиг хонжоо хайсан үйлдвэрлэлээ татгалзаж, хүрээлэн буй орчин, нийгмийн өмнө хариуцлага хүлээж эхэллээ.

Хээнцэр дэгжин бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хувцас загвар нь үнэндээ байгаль орчинд хамгийн халтай, үрэлсэн салбар гэдэг. Хөвөн даавуун нэг цамц үйлдвэрлэхэд нийт 2.7 тонн ус зарцуулдаг байна. Дэлхийн хэмжээнд хувцас үйлдвэрлэгчид жилд дунджаар 378 тэрбум литр усар туйлдаг байх жишээний. Мөн уснаас гадна эрчим хүчний "мангасууд". Эрчим хүчний хамгийн өндөр хэрэглээтэй 10 салбарын нэгд тооцогддог хувцас загварынхан гадагшлуулж буй хог хаягдлын хэмжээгээрээ харин хоол хүнсний дараа буюу хоёрдугаарт бичигдэж буй. Мөн 1980-аад онтой харьцуулахад дэлхий нийт өдгөө хувцасны шүүгээндээ дөрөв дахин их хувцас хадгалдаг болжээ.

Гэтэл хаягдсан хувцасны 90 орчим хувийг дахин боловсруулж болохуйц түүхий эд байдаг аж.

Дэлхийн нэхмэл эдлэлийн зах зээл (мянган ам.доллар, хувиар)




Тиймээс дэлхийн байгаль орчинд нөлөөлдөг энэ салбарынхан үрэлэн, үр ашиггүй, аминч байдлаа өөрчлөөхөөр шийдэж, эх дэлхийн ирээдүйн төлөө дуу хоолойгоо хүргэж, чадах чинээгээрээ оролцож эхлээд байна. Өөрөөр хэлбэл, хувцас загвар гэдэг зөвхөн гоё даашир байгаа болж, томоохон үйлдвэрлэгчид ирээдүйг чиглэсэн үйлдвэрлэл эрхлэхийн тулд түүхий эдийн нийлүүлэлт, түүний хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллийг судалж, гарал үүслийг нь ул суурьтай харах болов.

Энэ санаачилгад Kering SA, Gucci, Stella McCartney, Patagonia зэрэг томоохон брэнд нэгдэн, хувцасны түүхий эдийн нийлүүлэлтийн сувгийг тодорхойлж, мөшгөх тогтолцоог хөгжүүлэх стратеги хэрэгжүүлж эхэлсэн. Тэгвэл дэлхийн үйлдвэрлэгчид манай түүхий эдийн ирээдүйд санаа зовниж буйгаа илэрхийлээд эхэллээ. Учир нь монгол ноолуурын экологийн тэнцвэр болон бусад зүйлд үзүүлж буй нөлөөтэй холбоотой санал шүүмжлэл хүчтэй бий болсон.

Тиймээс Монголын мал аж ахуй, ялангуяа ямаан сүрэг, ноолуурын тогтвортой нийлүүлэлтийг хангахад Монгол Улстай хамт-

Дэлхийн хувцас загварын зах зээл (их наяд ам.доллараар)



● **Хэдийгээр дахин боловсруулсан түүхий эдээр үйлдвэрлэх нь Adidas-ын ашгийг нэмэгдүүлдэг ч тус компани дахин боловсруулсан түүхий эдийн эрэлтээ нэмэгдүүлсээр байна.**

● **Бэлэн хувцас үйлдвэрлэлээр дэлхийд эхний тавд бичигддэг H&M групп 2030 он гэхэд байгальд хор хөнөөлтэй нэг ч түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй гэдгээ мэдэгджээ.**

● **Сүүлийн зуу орчим жилийн турш хүүхэд, эмэгтэйчүүдийг хямд хөлсөөр ажиллуулж, хөдөлмөрийг нь мөхлөж, ус, эрчим хүчийг их хэмжээгээр ашигладаг хэмээн шүүмжлүүлсээр ирсэн, муу нэртэй хувцас үйлдвэрлэгчид сүүлийн жилүүдэд эрс өөрчлөгдөөд байна.**

ран ажиллахаа мэдэгдээд буй. Францын тансаг эдлэлийн Kering групп гэхэд сүүлийн таван жилийн турш монгол ноолуурын тогтвортой үйлдвэрлэлийг дэмжихээр судалж байгаа аж. Үүний үр дүнд тус компани ноолуурын нийлүүлэлтэд гол үүрэг гүйцэтгэдэг монгол малчдын орлогыг нэмэгдүүлж, малын эрүүл мэндийг дээшлүүлснээр түүхий эдийн нийлүүлэлтээ тогтвортой хадгална гэх дүгнэлтэд хүрсэн байна. Тиймээс малын эрүүл ахуй, үүслийг нь ул суурьтай харах боломжтой хэмээн мэдэгдэв. Зөвхөн Kering гэлтгүй дэлхийд алдартай Gucci, H&M, UNIQ-LO брэнд ч манай ноолуурын нийлүүлэлтийг тогтвортой болгох шийдийг эрэлхийлсээр.

Бэлчээрийн доройтол, мал аж ахуйн түүхий эдийн гарц, малчдын амьжиргаа гээд бидэнтэй хэдийн нүүр тулсан сорилтуудаа Монгол Улс шийдэж чадаагүй суух зуур манай улсаас түүхий эд худалдан авдаг гадаадын компаниуд үүнд санаа зовниж эхэлжээ. Тиймээс түүхий эдийн баталгаат эх үүсвэртэй болохын тулд тэд өнөөдөр монгол малчны орлогыг нэмэгдүүлж, ямаан сүргийн экологид үзүүлэх нөлөөллийг бууруулахаар толгойгоо гашилгаж сууна.

Олон улсын байгууллагаас эхлээд гадаадын компаниуд хүртэл

манай мал аж ахуйн салбарын ирээдүй, Монгол Улсын экологийн тэнцвэрт байдалд санаа зовниж байхад бид үүнийг шийдэхээр дорвитой алхам хийж байгаа билүү. Жилийн жилд энэ салбараас олох орлогоо тооцохоос өөр, ноолуурын үйлдвэрлэл дагасан сүүдийг бид яагаад хөндөхгүй байна вэ. Цаашлаад энэ зөвхөн төрийн ажил биш хувийн эвшлийн, энэ салбартай холбоотой оролцогч бүрт хамаатай сэдэв болохыг гадаадын компаниуд баталсаар байна.

Өнөөдөр Монгол Улсын ноолуурын салбарт том, жижиг 300 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг, том хэмжээний цогц үйлдвэртэй 6-7 компани бий. Гэтэл тэд бизнесийнх нь чухал хүчин зүйл болсон ноолуурын тогтвортой нийлүүлэлтийн талаар өнөөг хүртэл хөндөхгүй байна.

Мэдээж, дэлхийн том брэндүүдтэй харьцуулахад манай үйлдвэрлэгчид жижиг, санхүүгийн боломж сул. Гэхдээ нийгэм, экологи рүү чиглэсэн хувийн эвшлийн санаачилга хэзээд багаддаггүй. Цаашлаад орчин цагт амжилттай бизнесийг зөвхөн санхүүгийн тайлан дахь ашгийн үзүүлэлтээр хэмжихээ больсон. Харин нийгмийн хариуцлага, компанийн засаглал, нийгэм, хүрээлэн буй орчноос авсныхаа хэрээр өгдөг эргэх холбоо шинэ цагийн бизнесийн гол тодорхойлолт болсон билээ. [ZGM]

DOW JONES	S&P 500	FTSE 100	NIKKEI 225	TOPIX	SHANGHAI COMPOSITE	HANG SENG	KOSPI
0.17%	0.20%	0.21%	0.46%	0.82%	1.20%	0.05%	0.27%